ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2021-09-14

Тендерийн дугаар: МРЦМ/202102488

“Монголросцветмет” ТӨҮГ нь эрх бүхий тендерт оролцогчдыг ***“Техникийн нөхөн сэргээлт хийх”*** */дүйцүүлэн хамгаалах/* үйлчилгээ үзүүлэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн бичиг баримтыг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр 50.000 төгрөгөөр www.tender.gov.mn цахим системээс худалдан авах боломжтой. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш *30* хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2019, 2020 оны аль нэг жилд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 50%-иас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 50%-иас багагүй байна.

Сүүлийн 5 жилийн аль нэгд ижил төстэй ажил гүйцэтгэж байсан туршлагатай байна.

Тендерийн хамт 1,900,000 төгрөгийн тендерийн баталгааг ирүүлнэ.

Тендерийг **2021 оны 09 дүгээр сарын 20-ны** өдрийн 09:10 цагаас өмнө ***Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем*** **www.tender.gov.mn** хаягаар ирүүлэх бөгөөд **2021 оны 09 дүгээр сарын 20-ны** өдрийн 09:15 цагт цахимаар нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг **www.tender.gov.mn** хаягаар авч болно.